



СХЗХЭЛТЭСТ

2013 оны Санхүүгийн Тайлан

Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан Аймгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

Лавлах зүйлс байвал доорх хаягаар

холбоо барина уу:

Аймгийн Ерөнхий Аудитор

Л.Жаргалсайхан

Утас: 70272585

И-мэйл

Аудитын багийн аудитор :

Ц.Саранчимэг

Шинжээч :

Ч.Бат-Эрдэнэ

Утас: 70273204

И-мэйл

baterdenechuka@yahoo.com

ТӨАГ-ын хаягийг оруулах

Төв аймаг Зуунмод сум 1-р баг Төрийн
байгууллагуудын ордон

• Танилцуулга	3
• Санхүүгийн дотоод хяналт	3
• Гол шийдлүүд	4
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	5
• Аудитын санал дүгнэлт	5

СХЗХэлтсийн 2013 оны Санхүүгийн Тайланд**ААГ аудит хийж дууссан тухай мэдэгдэл**

Бид Стандартчилал хэмжил зүйн хэлтсийн 2013 оны Санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба СХЗХэлтсийн даргад энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаархи бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд СХЗХэлтэс нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

- Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг **тодруулвал:**
- Орлого санхүүжилт, бараа ажил үйлчилгээний урсгал зардал, цалингийн зардал, бараа материал, үндсэн хөрөнгө авлага, мөнгөн хөрөнгө, өглөг бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

Гол илрүүлсэн зүйлс буюу аудитын үр дүнгээс гарсныг торуулвал:

- Санхүүгийн байдлын тайланд 51585.4 мянган төгрөгний мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гэж буруу тайлагнасан.
- Албан хаагчдад Сангийн сайдын 2011 оны 132 тоот тушаалаар батлагдсан албан томилолтын зардлын нормативаас дутуу олгосон байна.
- Өглөг, авлагын тайлангаар зардлын зүйлээр сонгосон авлага, өглөг нь бараа материалын дансдын дүнтэй тохирохгүй байна.
- Стандартчилал хэмжил зүйн газраас хуваарилсан үндсэн хөрөнгийг орлого авахдаа Сангийн сайдын 2013 оны 12-р сарын 2-ны 269 тоот тушаалыг зөрчиж Засгийн газрын хувь оруулсан капитал дансыг нэмэгдүүлэн авсан.

ЕМ, Санхүүгийн албаны даргаас Аймгийн Аудитын Газар тайлбар мэдүүлэг хүлээж байгаа илэрсэн алдааг хэрхэн залруулсан талаар тайлбар ирүүлнэ үү

Санхүүгийн тайлангийн аудитаар ажлын баримтанд үндэслэн 54233.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 54233.5 мянган төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж материаллагын урьдчилан

тогтоосон түвшингээс бага байгаа тул
Зөрчилгүй санал дүгнэлт гаргахаар
Ерөнхий аудиторт санал оруулсан байгаа.

Аймгийн Ерөнхий Аудитор 2013 оны 1-р сарын 24-ны өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад Ерөнхий нягтлан бодогч Д.Энхзул нь бидэнтэй хамтран ажиллаж бидний ажилд дэмжлэг болж байсанд гүнээ талархаж байна.

Шинжээч Ч.Бат-Эрдэнэ
Төв Аймгийн Аудитын Газар

Танилцуулга

1. Бид Стандартчилал хэмжил зүйн хэлтсийн 2013 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болсон санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба Стандартчилал хэмжил зүйн хэлтсийн даргад энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Стандартчилал хэмжил зүйн хэлтэс нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.
2. Бидний 2013 оны тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:
 - Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
 - Жилийн санхүүгийн тайланд аудит хийх.

Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Санхүүгийн дотоод хяналтыг дахин шалгах

3. ААГ санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь Стандартчилал хэмжил зүйн хэлтсийн хяналтыг аймгийн Аудитын газрын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм.

Бид Стандартчилал хэмжил зүйн хэлтсийн даргад тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.

4. Дараахь түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Стандартчилал хэмжил зүйн хэлтсийн удирдлагын анхаарлыг хандуулж байна:

1. Орлого санхүүжилтийн талаар

Төв аймгийн Стандартчилал хэмжил зүйн хэлтэс нь 2013 оны санхүүгийн тайлангаар тайлант онд улсын төсвөөс 146833.4 мянган төгрөгний санхүүжилт авахаар батлагдснаас 146765.9 мянган төгрөгийн санхүүжилт авч 67.5 мянган төгрөгөөр дутуу санхүүжилт авсан байна. Үндсэн үйл ажиллагааны орлогоор 22500.0 мянган төгрөгийн орлого оруулахаас 59522.4 мянган төгрөгний орлого оруулж, батлагдсан төлөвлөгөөг 37022.4 мянган төгрөгөөр буюу 264.5 хувиар давуулан биелүүлсэн байна. Үндсэн бус үйл ажиллагааны орлогоор 2000.0 мянган төгрөгний орлого олсон байна.

УБЦТС ХХК нь аймгийн хэмжээнд хуучин механик тоолуурыг электрон тоолуураар солихтой холбогдуулан тус хэлтсийн тоолуур баталгаажуулалтын орлого өссөн байна.

“Хэрэглэгчийн боловсролын төв”-ийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор өрөөний тохижилтод зориулж аймгийн Засаг даргын захирамжаар 2000.0 мянган төгрөгний санхүүгийн дэмжлэг үзүүлсэн нь үндсэн бус үйл ажиллагааны орлогоор бүртгэгдсэн байна.

Үнэт цаасны тооцоог улирал бүр хийж тооцоо бодсон байна.

2.Бараа үйлчилгээний зардлын талаар

Нарийвчилсан сорилыг Nagstab9 загвар программыг ашиглан хийлээ. Уг сорилоор түлш халаалтын батлагдсан төсвөөс хэмнэгдсэн 3700.0 мянган төгрөг, гэрэл цахилгааны батлагдсан төсвөөс 360.0 мянган төгрөг, цэвэр бохир усны зардлаас 380.0 мянган төгрөг, жижиг эд хогшил худалдан авах зардлын батлагдсан төсвөөс 100.0 мянган төгрөгүүдийг ЗЭБ-5 төсвийн зардал хоорондын шилжүүлгийн хүсэлтийг 2013 оны 7-р сарын 16-нд, 11-р сарын 26-нд тус тус гаргаж бичиг хэргийн зардалд 890.0 мянган төгрөгийг, шуудан холбооны зардалд 250.0 мянган төгрөгийг, тээвэр шатахууны зардалд 750.0 мянган төгрөг, албан томилолтын зардалд 850.0 мянган төгрөгийг, урсгал зардалд 450.0 мянган төгрөгийг, төлбөр хураамж болон бусад зардалд 950.0 мянган төгрөгийг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалын зардалд 400.0 мянган төгрөгийг тус тус гүйлгэн зарцуулсан байна.

Хэлтсийн хөдөлмөрийн дотоод журмын дагуу төрийн захиргааны албан хаагчид суманд ажиллахад 15000 төгрөг, аймгийн төвд 20000 төгрөг, Улаанбаатар хотод 23000 төгрөг, үйлчилгээний албан хаагч суманд 12000 төгрөг, аймгийн төвд 17000 төгрөг, Улаанбаатар хотод 20000 төгрөгөөр тооцож олгохоор тогтсоны дагуу олгосон байна.

Төсөвт зардлыг батлуулахдаа үндэслэлгүй батлуулсан байна. Ялангуяа түлш халаалтын зардал их хэмжээгээр хэмнэгдэж байгаа бөгөөд түүнээс бусад зардлууд руу гүйлгэн зарцуулах, улмаар батлагдсан төсөвт зардал нэр зүйлээрээ хэтрэх үндэслэл болж байна.

3.Цалингийн талаар

Санхүүгийн програмаар сүүлийн 8 сарын цалинг бодсон байна. Энэ нь аудитын явцад цалингийн тооцооллыг шалгахад хүндрэлтэй байсан тул шалгаагүй болно. Цалингийн зардал нь өмнөх оноос 4.3 хувиар өссөн нь ажилчдад олгодог хоолны хөнгөлөлтийг урьд нь бараа үйлчилгээний бусад зардалд хоолны зардалд баталдаг байсныг 2013 онд цалингийн санд хоолны хөнгөлөлт болгон баталсантай холбоотойгоор цалингийн сан өссөнтэй байна

Цалинг эхний 8-н сар санхүүгийн программаар бодоогүй. 2 жижүүрт ТҮ-1-4 гэсэн мөртлөө үндсэн цалинг илүү тогтоож цалинжуулсан. Цалингийн сангаас 3-р сард 5 хүнд урамшуулал олгосон мөн СХГазрын хүмүүсийг цалингийн санд баталсан хоолны хөнгөлөлтийн зардлаас хооллосон. Гэрээт ажилчинд үр дүнгийн урамшуулал олгосон байна.

4.Бараа материал

Тайлант онд тус хэлтсийн бараа материал данс нь 3731.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба 10581.3 мянган төгрөгийн орлогын, 11999.6 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийж 2313.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Бараа материалын үлдэгдлийг 2013 оны жилийн эцсийн тооллогын комиссын дүнтэй тулган шалгахад Байгууллагын эд хөрөнгийн жилийн эцсийн тооллого

хийсэн илтгэх хуудас эд хөрөнгийн тооллогын бүртгэлд нийт 2313.5 мянган төгрөгийн бараа материалын эд хөрөнгө тоолсон байна. Энэ нь байвал зохих бараа материалын үлдэгдлээс зөрүүгүй байна. 2013 оны эцэст тохирлын гэрчилгээ 500 ширхэг, бэлэн мөнгөний тасалбар 150 ширхэг, хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын гэрчилгээ 100 ширхэг, жингийн гэрчилгээ 400 ширхэг /1303594-1303993/, цахилгаан тоолуурын гэрчилгээ байхгүй байна. Тооллогын комисс тайлангаа бичиж өгөхдөө бараа материал дансны үлдэгдлийг 2313.5 мянган төгрөгийг 2131.5 гэж андуурсан байна.

5. Үндсэн хөрөнгө

Тайлант онд үндсэн хөрөнгийн тайлангаар 2648.1 мянган төгрөгийн орлогын гүйлгээ, зарлагын гүйлгээ хийгдэлгүй, 12490.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцож тайлангийн эцэст 246636.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Стандартчилал хэмжил зүйн газраас 2013 оны 6-р сард бүх аймгууд руу принтер, зөөврийн компьютер, хувцасны шүүгээ, архивийн шүүгээ зэргийг хуваарилсныг орлого авсан байна. Уг хөрөнгүүдийг орлого авахдаа Сангийн сайдын 2013 оны 12-р сарын 2-ны 269 тоот тушаалыг зөрчиж Засгийн газрын хувь оруулсан капитал дансыг нэмэгдүүлэн авсныг аудитын хугацаанд залрууллаа.

6. Авлага, өглөг

Өглөг, авлагын тайлангаар зардлын зүйлээр сонгосон авлага, өглөг нь бараа материалын дансдын дүнтэй тохирохгүй байна. Тайлант хугацаанд үүссэн өглөг, авлагыг тухай бүрт нь барагдуулж ажилласан байна.

7. Мөнгөн хөрөнгийн талаар

Байгууллагын харилцах болон кассын дансанд 2013 оны эхэнд төгрөгийн үлдэгдэлгүй байсан байна. Тайлант хугацаанд үндсэн үйл ажиллагааны батлагдсан төлөвлөгөөнөөс давж биелсэн 37022.4 мянган төгрөг, төсөвт зардлын хэмнэлт 14562.9 мянган төгрөг нийт 51585.4 мянган төгрөгний үлдэгдэлтэй гэж санхүүгийн тайлагнасан бөгөөд харилцахын дансны хуулгыг шалгахад дансны үлдэгдлийг төрийн сан татан төвлөрүүлсэн байсан. Иймд аудит хийх хугацаанд санхүүгийн байдлын тайланд мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй болгож залруулга хийсэн. Харилцах дансны баримтын бүрдүүлэлт хангалттай сайн.

Бидний дахин шалгалтын үр дүнд дээр дурдсан 7 хэсгүүдийн дотоод хяналтын ситем нь тухайн жилд хангалттай байсан нь санхүүгийн тайланг үнэн зөв бодиттой бэлтгэж толилуулна гэсэн НББОУСтандарт, НББ-ийн тухай хууль бусад заавар журамд нийцэж байна. Дээрхи зөрчлийг сайжруулах шаардлагатай байж болох санхүүгийн хяналтын талаар удирдлагын захидалд тусгасан болно.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

5. Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

- ✓ Төсөвт зардлыг бодитой төлөвлөж, тайлагнах

- ✓ Албан хаагчдын албан томилолтын зардлыг Сангийн сайдын 2011 оны 132 тоот тушаалын дагуу олгож байх
- ✓ Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дах заалтын дагуу цалингийн санд батлагдсан хоолны хөнгөлөлтийн зардлаас зориулалт бусаар зардал гаргахгүй байх
- ✓ Өглөг, авлагыг үүсгэж барагдуулахдаа холбогдох дансны зүйлийг зөв сонгох

Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн

Залруулагдаагүй алдаа

6. Аудитын стандарт нь Аймгийн Аудитын газарт аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Аудитаар илрүүлсэн өглөгийн тайлан нь нэр, зүйл нь зөрүүтэй тайлагнагдсан болно.

Тайлбар мэдүүлгийн захидал

7. Аудитын үйл явцад Аймгийн Аудитын газар хөндлөнгийн шинжээчийн хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд /тайлбар мэдүүлгийн захидлаар/ санхүү бүртгэлийн даргаас эдгээр батлагааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Өмнөх зөвлөмжийн биелэлт

8. 2012 оны санхүүгийн тайлангийн аудитаар

- ✓ Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөлтийг бодитой төлөвлөх
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн программыг бүрэн ашиглаж цалинг программаар бодох
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС-ын дагуу өглөг, авлагыг бүртгэж байх
- ✓ Дотоод хяналт шалгалтын тайланг байгууллагын хурлаар хэлэлцүүлж, илэрсэн зөрчил дутагдлыг залруулах талаар тодорхой ажил зохиох

Эдгээр 4-н зөвлөмжөөс нягтлан бодох бүртгэлийн программыг бүрэн ашиглаж цалинг программаар бодох, дотоод хяналт шалгалтын тайланг байгууллагын хурлаар хэлэлцүүлж, илэрсэн зөрчил дутагдлыг залруулах талаар тодорхой ажил зохиох гэсэн зөвлөмжүүд хэрэгжиж, бусад зөвлөмжүүд хэрэгжээгүй байна гэж дүгнэлээ.

Аудитын санал дүгнэлт

9. Аймгийн Аудитын газраас танай байгууллагын 2013 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болгосон санхүүгийн тайланд **зөрчилгүй** санал дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

Аймгийн Аудитын газар

2013.01.23